



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1152

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.4, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6, 40.2, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 оны №04/41 тоот “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй, мөн газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй Хүрэлсүх овогтой Бат-Эрдэнийн Засаг даргын Тамгын газрын баруун талд Дэлгүүрийн зориулалтаар эзэмшүүлсэн 0,0625 га газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгон газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Газар эзэмших эрх нь хүчингүй болгосныг иргэн Хүрэлсүх овогтой Бат-Эрдэнэд мэдэгдэж, холбогдох бичиг баримтыг хүлээж авахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны А/191 дүгээр захирамжийн хавсралт 3 дахь хүснэгтийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.ЯГААНЦЭЦЭГ

